



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/Н06.

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 3.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Софт волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд орон нутгаас оролцох тамирчдын зардалд 500,000 (таван зуун мянга), граунд гольфын улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд орон нутгаас оролцох тамирчдын зардалд 1,000,000 (нэг сая), нийт 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Дээрх 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100903